



ЦАГДААГИЙН ЕРӨНХИЙ ГАЗРЫН  
ДАРГЫН ТУШЛАЛ

1000 оны 06 сарын 20 өдөр

Дугаар 1001

Улаанбаатар хот

Г Дүрэм батлах тухай Г

Засгийн газрын агентлагийн эрх зүйн байдлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.4, Цагдаагийн албаны тухай хуулийн 81 дүгээр зүйлийн 81.2 дахь хэсгийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. "Цагдаагийн алба хаагчийн ёс зүйн дүрэм"-ийг нэгдүгээр, "Цагдаагийн алба хаагчийн сахилгын дүрэм"-ийг хоёрдугаар хавсралтаар тус тус баталсугай.
2. Дүрмийг алба хаагчдаар судлуулж, үйл ажиллагаандaa мөрдүүлж ажиллахыг алба, нэгж, нутаг дэвсгэр хариуцсан цагдаагийн байгууллагын дарга нарт үүрэг болгосугай.
3. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Дэд дарга /цагдаагийн хурандаа О.Амарсанаа/-д даалгасугай.
4. Энэ тушаал гарсантай холбогдуулан Цагдаагийн ерөнхий газрын даргын 2017 оны А/129 дүгээр тушаалыг хүчингүй болсонд тооцсугай.
5. Тушаалыг батлагдсан өдрөөс эхлэн дагаж мөрдсүгэй.

ДАРГА,  
ХОШУУЧ ГЕНЕРАЛ

Ж.БОЛД



Цагдаагийн өрөнхий газрын даргын  
2022 оны 04 дугаар сарын 28-ны  
өдрийн 10 дугаар тушаалын  
нэгдүгээр хавсралт

## ЦАГДААГИЙН АЛБА ХААГЧИЙН ЁС ЗҮЙН ДҮРЭМ

Нэг. Нийтлэг үндэслэл

1.1. Цагдаагийн алба хаагч, ажилтны үйл ажиллагаанд баримтлах ёс зүйн нийтлэг хэм хэмжээг тогтоон хэвшүүлэх, хяналт тавих, гэмт хэрэг, зөрчил үйлдэх, ёс зүй, сахилгын зөрчил гаргахаас сэргийлэх, иргэдийн цагдаагийн байгууллагад итгэх итгэлийг нэмэгдүүлэхэд энэ дүрмийн зорилго оршино.

1.2. Энэ дүрмийн зорилт нь цагдаагийн албаны үнэт зүйл<sup>1</sup>, алба хаагчийн ёс суртахууны нийтлэг хэм хэмжээ шаардлагыг тодорхойлж, түүнийг хангуулах үйл ажиллагааны зохион байгуулалт, журмыг тогтоож, ёс зүйн хариуцлага хүлээлгэхтэй холбогдсон харилцааг зохицуулна.

1.3. Цагдаагийн алба хаагчийн ёс зүйн дүрэм нь Монгол Улсын Үндсэн хууль, Төрийн албаны тухай хууль, Авлигын эсрэг хууль, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль, Цагдаагийн албаны тухай хууль, НҮБ-ын Ерөнхий Ассамблейн 1979 онд баталсан Хууль хэрэгжүүлэх албан тушаалтнуудын зан үйлийн тухай хууль, Интерполоос баталсан дүрэм, журам, олон улсын гэрээ болон бусад хууль тогтоомжийн акт, Хууль зүй, дотоод хэргийн сайдын 2022 оны A/105 дугаартай тушаалаар баталсан “Салбарын төрийн алба хаагчийн ёс зүйн үлгэрчилсэн загвар” болон энэхүү дүрмээс бүрдэнэ.

1.4. Энэ дүрмийг алба хаагч үйл ажиллагаандаа мөрдлөг болгох бөгөөд байгууллагын нэр хүндэд харшлах аливаа зохисгүй үйлдэл гаргахгүй байх, хууль, цагдаагийн алба хаагчийн нэр төр, ёс зүйг дээдлэн хүндэтгэж, сахин биелүүлнэ.

1.5. Энэ дүрэмд хэрэглэсэн дараах нэр томъёог дор дурдсан утгаар ойлгоно:

1.5.1. “цагдаагийн алба хаагчийн ёс зүйн хэм хэмжээ” гэж энэ дүрмээр тогтоосон ёс зүйн нийтлэг хэм хэмжээ, түүнд нийцүүлэн гаргасан тушаал, шийдвэр, түүнчлэн нийгэм, хамт олон, гэр бүлийн харилцааны хүрээнд дагаж мөрдвөл зохих зан үйлийн нийлбэр цогцыг;

1.5.2. “цагдаагийн алба хаагчийн ёс зүйн зөрчил” гэж холбогдох хууль тогтоомж болон энэ дүрмээр тогтоосон ёс зүйн хэм хэмжээг зөрчсөн үйлдэл, эс үйлдэхүйг;

1.5.3. “цагдаагийн алба хаагчийн ёс зүйн хариуцлага” гэж цагдаагийн алба хаагчийн ёс зүйн зөрчилд хүлээлгэх хариуцлагын арга хэмжээг;

1.5.4. “ноцтой зөрчил” гэж хууль тогтоомжид заасан, цагдаагийн албаны нэр хүндэд харшлах үйлдэл хийх, эд хөрөнгийн хохирол учруулах зэргээр эрх, ашиг сонирхолд сергээр нөлөөлөх, үр дагаврыг бий болгох, энэ дүрэмд заасан зөрчлийг сахилгын шийтгэлгүйд тооцох хугацаа өнгөрөөгүй үед 2 буюу түүнээс дээш зөрчсөн үйлдэл, эс үйлдэхүйг.

1.6. Цагдаагийн алба хаагч нь бусдын ёс зүйн хэм хэмжээг зөрчсөн үйлдэл, эс үйлдэхүйг үл тэвчинэ.

<sup>1</sup> [www.police.gov](http://www.police.gov) Цагдаагийн байгууллагын үнэт зүйл “Эх орон, ард иргэддээ өргөсөн тангараг”

## Хоёр. Ёс зүйн хэм хэмжээ

**2.1.Цагдаагийн алба хаагч нь хууль дээдлэх зарчмын хүрээнд дараах ёс зүйн хэм хэмжээг дагаж мөрдөнө:**

**2.1.1.Монгол Улсын Үндсэн хууль, бусад хууль тогтоомж, хэм хэмжээний эрх зүйн акт, дээд шатны байгууллага, албан тушаалтны хуульд нийцсэн шийдвэрийг ёсчлон биелүүлж, захирах, захирагдах ёсны зарчмыг баримтлах;**

**2.1.2.төрт ёс, түүх, соёлынхоо уламжлалтыг нандигнан хүндэтгэж, хүний нэр төр, алдар хүнд, эрх, хууль ёсны ашиг сонирхлыг дээдлэн хүндэтгэх;**

**2.1.3.Үндсэн хууль, бусад хууль тогтоомж, эрх зүйн акт, байгууллагын хэмжээнд мөрдөж байгаа дүрэм, журам, заавар, байгууллагын соёл, дэг журмыг чанд баримтлах;**

**2.1.4.алба хаагч нь албан үүргээ хэрэгжүүлэхдээ хариуцлагатай, сахилга баттай ажиллах ёстой бөгөөд аливаа шийдвэр гаргахдаа асуудал (гомдол, хүсэлт, өргөдөл зэрэг), хэрэг, маргааны үйл баримт, хэрэглэх хууль тогтоомжийг бүхий л талаас нь нухацтай дүгнэн шинжилж, аливаа эргэлзээ тээнэгэлзэлгүй болтол нь тунгаан лавшруулж шалгасан бодит дүгнэлтэд үндэслэж байх;**

**2.1.5.алба хаагч нь хэрэг, маргаан, асуудлын талаар сэжиг таамагт үндэслэн урьдчилан дүгнэлт хийж, түүнийгээ батлахын тулд улайран хөөцөлдөж, нэг талыг баримтлах ёсгүй бөгөөд өөрт мэдээжийн санагдсан таамаг буюу эсвэл шийдлийг шүүрэн авч хэрэглэх замаар хөнгөн хийсвэр хандахгүйгээр тухайн асуудлыг байнга лавшруулан нягталж, эргэж магадалж байх;**

**2.1.6.төр, байгууллага, хувь хүний нууцыг хуульд заасан үндэслэл, журмаас гадуур бусдад задруулах, удирдах албан тушаалтны зөвшөөрөлгүйгээр албан ажлын мэдээллийг нийтэд болон бусдад мэдээлэхгүй байх;**

**2.1.7.байгууллагаас тогтоосон хөдөлмөрийн дотоод журам, албан тушаалын тодорхойлолтод заасан чиг үүргийг чанд сахин биелүүлж, албаны бус зорилгоор материал-техникийн, санхүүгийн хэрэгсэл, төрийн бусад эд хөрөнгө, албаны мэдээллийг ашиглахгүй, бусдад шилжүүлэхгүй байх;**

**2.1.8.хууль зөрчсөн, авлига авсан, албаны эрх мэдэл буюу албан тушаалын байдлаа урвуулах, хэтрүүлэн ашигласан аливаа үйлдэлтэй эвлэрэхгүй байх бөгөөд албан үүргээ зохих ёсоор хэрэгжүүлэхэд нөлөөлсөн аливаа дарамт, шахалт, аливаа нөлөөллийн талаар өөрийн удирдах албан тушаалтан, эсхүл эрх бүхий байгууллага, албан тушаалтанд мэдэгдэх;**

**2.1.9.цагдаагийн алба хаагч нь хууль тогтоомжид зааснаас бусад ажил, албан тушаал эрхлэхгүй байх;**

**2.1.10.цагдаагийн алба хаагч дээд шатны цагдаагийн байгууллага, албан тушаалтны гаргасан хууль бус шийдвэрийг биелүүлэхээс татгалзах.**

**2.2.Цагдаагийн алба хаагч хүний эрх, эрх чөлөөг хүндэтгэх, тэгш байдлыг хангах зарчмын хүрээнд дараах ёс зүйн хэм хэмжээг дагаж мөрдөнө.**

**2.2.1.ард түмэндээ чин сэтгэлээсээ үйлчилж, цагдаагийн албаны нэр хүндийг эрхэмлэн дээдлэх;**

**2.2.2.алба хаагч нь албан үүргээ хэрэгжүүлэх явцдаа хэнийг ч үндэс угсаа, хэл, арьсны өнгө, нас, хүйс, нийгмийн байдал, гарал, хөрөнгө чинээ, эрхэлсэн ажил, албан тушаал, шашин шүтлэг, үзэл бодол, боловсрол, эрүүл мэндийн байдал, бэлгийн чиг хандлагаар нь ялгаварлан гадуурхах ёсгүй бөгөөд иргэнтэй шударга, тэгш харьцаж байгаагаа хөндлөнгийн хэнд ч ойлгогдох байдлаар илэрхийлж, хэвлэл мэдээлэл, олон нийттэй харилцахдаа төвийг сахисан байдлыг хангаж, хувийн итгэл үнэмшил, үзэл бодлоо илэрхийлэхээс зайлсхийж байх;**

**2.2.3.алба хаагч нь албан үүргээ гүйцэтгэх явцдаа хууль тогтоомжоор итгэж**

хүлээлгэсэн бүрэн эрхээ хэрэгжүүлэхдээ иргэнтэй эелдэг, хүлээцтэй, тэвчээртэй, ажил хэрэгч, зарчимч, даруу төлөв харьцаж байх ёстой бөгөөд бүдүүлэг, хүйтэн цэвдэг, дээрэнгүй, балмад согтуу хөлчүү харьцах, түүнийг айлан сүрдүүлэх, дарамтлах, хясан боогдуулах, эрхшээлдээ оруулах, хувийн харьцаа тогтоох, басамжлан доромжлохгүй байх;

2.2.4.алба хаагч нь олгогдсон эрхийг хуульд нийцүүлэн ашиглах бөгөөд үйл ажиллагааны явцад иргэн ба аж ахуйн нэгжийн эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хөндөх ёсгүй бөгөөд цагдан хорих, барьцаа авах зэрэг таслан сэргийлэх арга хэмжээг хэрэглэх, баривчлах зэрэг шийтгэлийг ногдуулахдаа хуульд заасан үндэслэл тухайн тохиолдолд бодитой баримттай байгаа эсэхийг нухацтай авч үзэж, лавшуулан шалгаж, алдаа гаргахаас байнга сээрэмжлэх;

2.2.5.бусдад эрүү шүүлт тулгаж, хүнлэг бус, хэрцгий хандаж, нэр төрийг нь доромжлон харьцахгүй байх;

2.2.6.албан тушаалын бүрэн эрхээ урвуулан ашиглах, бусдыг бэлгийн болон хувийн ашиг сонирхолдоо нийцүүлэн аливаа хэлбэрээр дарамт шахалт үзүүлэх, хавчин гадуурхах, эрхшээлдээ оруулахгүй байх;

2.2.7.албан тушаалын бүрэн эрхээ хэрэгжүүлэхдээ хамтран ажиллаж байгаа алба хаагч, ажилтантай хүндэтгэлтэй, хүлээцтэй, адил тэгш харилцаж, тэдний нэр төр, алдар хүнд, хууль ёсны эрх, ашиг сонирхлыг хүндэтгэх;

2.2.8.алба хаагч биеийн хүч, тусгай хэрэгсэл, галт зэвсэг хэрэглэхийг урьтал болголгүй гагцхүү тэдгээрийг албан үүргээ гүйцэтгэхэд зайлшгүй онцгой тохиолдолд шаардагдах хэр хэмжээнд тохируулан ашиглаж байх;

2.2.9.алба хаагч нь гэмт хэрэг, зөрчил золгүй тохиолдоос хохирсон болон биеэ хамгаалж чадахгүй өөр бусад байдлаар амь нас нь аюултай байгаа иргэнд хүнлэг энэрэнгүй хандаж, юуны өмнө эмчийн өмнөх тусламж үзүүлэх ёстой бөгөөд саатуулагдсан хүмүүсийн эрүүл мэндийг бүрэн хамгаалах, шаардлагатай тохиолдолд эмнэлгийн тусламж үзүүлэх яаралтай арга хэмжээ авах

2.3.Алба хаагч шударга ёсны зарчмын хүрээнд дараах ёс зүйн хэм хэмжээг дагаж мөрдөнө:

2.3.1.алба хаагч нь шударга зан үйлийг эрхэмлэн баримталж, хүлцэж болох алдаа дутагдал байдаг ч хэрэв төрийн албан хаагч шударга бус зан үйл гаргавал иргэд яагаад ч уучилж үздэггүй, шударга бус явдлыг тэвчдэггүй гэдгийг цаг ямагт онцгой анхаарч, голч шударга байдлыг төрийн албан хаагчийн ёс зүйн хамгийн нандин чанар хэмээн үзэж байх;

2.3.2.алба хаагч нь хувийн болон нийгмийн амьдралдаа нэр төртэй, үнэнч, зарчимч, хүндлэл төрүүлэхүйц байдлыг эрхэмлэж байх;

2.3.3.алба хаагч нь хахууль авах ёсгүй бөгөөд хахууль нь шударга ёс болон ёс суртахууны нандин чанарыг хөсөрдүүлж, төрийн нэр хүндийг олон түмний дунд гутаадаг учрыг сайтар ухамсарлах ёстой бөгөөд албан үүргээ гүйцэтгэсэнтэй холбогдуулан хувь хүн болон хуулийн этгээдээс шагнал (бэлэг, мөнгөн шагнал, зээл үйлчилгээ, зугаа цэнгэлийн ба амралтын төлбөр, тээврийн хэрэгслийн зардал болон бусад шагнал) авахыг хатуу цээрлэж байх;

2.3.4.хууль, тогтоомжид заасны дагуу өөрийн болон гэр бүлийн гишүүдийн өмчийн байдал, түүнд орсон өөрчлөлт, орлогын талаар хөрөнгө орлогын мэдүүлэгтээ үнэн зөв, бүрэн мэдүүлэх;

2.3.5.хамтран ажиллаж байгаа алба хаагч, байгууллага, хуулийн этгээдийн үйл ажиллагаанд хүндэтгэлтэй хандаж, хөндлөнгөөс хууль бусаар нөлөөлөхгүй, харьяаллын бус хэрэг маргаанд оролцохгүй байх;

2.3.6.авлига, хээл хахууль авах, өгөх, зуучлахгүй байх;

2.3.7.албан үүргээ гүйцэтгэх явцдаа олж авсан мэдээ, мэдээллийг цагдаагийн байгууллага, алба хаагчийн нэр төрд харшлах болон өөрийн санхүү, эдийн засгийн аливаа хэлцэл, хөрөнгө оруулалт, эдийн засгийн бусад ашиг сонирхлоо хэрэгжүүлэх үйл ажиллагаанд ашиглахгүй байх, зуучлахгүй байх;

2.3.8.албан тушаал, хуулиар олгогдсон эрх мэдлээ хувийн зорилгод ашиглахгүй байх, албан үүргээ гүйцэтгэхтэй холбогдуулан аливаа этгээдэд давуу байдал бий болгох, үгсэн тохирох, амлалт өгөх, шан харамж авах, үйлчилгээ, зээл авах, ийнхүү авахаар шахаж шаардах, ятгах, бусдад зуучлах, хуульд харш болзол тавих, далайлган сурдүүлэх, бусдын өмч хөрөнгийг хувийн болон албан ажилд ашиглахгүй байх;

2.3.9.алба хаагчийн шалгаж байгаа мэдээ, мэдээлэл, өргөдөл, гомдол, хүсэлт нь ашиг сонирхлын зөрчил үссэн, үүсэж болзошгүй нөхцөлд албан үүргээ гүйцэтгэхээс татгалзаж, энэ тухай эрх бүхий байгууллага, албан тушаалтанд бичгээр мэдэгдэх;

2.3.10.цагдаагийн байгууллагын нэр төр, алдар хүндэд харшлах аливаа үйлдэл, эс үйлдэл гаргахгүй байх;

2.3.11.албан үүргээ гүйцэтгэхдээ улс төрийн хувьд төвийг сахиж, улс төрийн нам, эвсэл, хөдөлгөөний аливаа нөлөөллөөс ангид байх;

2.3.12.албан үүргээ зохих ёсоор биелүүлээгүйн төлөө хариуцлага хүлээдэг байна.

2.4.Алба хаагч ёс суртахуунтай зарчмын хүрээнд дараах ёс зүйн хэм хэмжээг дагаж мөрднө:

2.4.1.байгууллагын зорилт, чиг үүргийг хэрэгжүүлэх талаар төрийн байгууллагаас явуулж байгаа аливаа үйл ажиллагааг эсэргүүцсэн мэдээ, мэдээлэл тараахгүй байх, энэ төрлийн арга хэмжээг зохион байгуулж, оролцохгүй байх;

2.4.2.албан ажилд шаардлагатай мэдээллийг нуун дарагдуулах, буруу мэдээллээр хангах замаар удирдлагын шийдвэр гаргах үйл ажиллагаанд саад учруулахгүй байх;

2.4.3.хуулиар тогтоосон бүрэн эрхээ нарийн нягт, няхуур, нухацтай, өндөр шаардлага тавьж, өөртөө хяналт тавьж хэрэгжүүлэх нь аливаа эндэгдэл гаргахаас сэргийлж байх;

2.4.4.удирдах албан тушаалтан ёс зүйн хувьд бусдад үлгэр дууриалал үзүүлж байх;

2.4.5.алба хаагч нь албаны үүргээ хэрэгжүүлэхдээ итгэл дааж ажиллах бөгөөд голч шударга, үнэнч, чармайлттай, туйлбартай, хүнийг сонсож чаддаг, тэсвэр тэвчээртэй, худал амладаггүй, хуурч мэхэлдэггүй, хоёр нүүрлэдэггүй чанараа хөсөрдүүлбэл итгэл даахгүй гэдгийг байнга санаж ажиллаж байхаас цагдаагийн байгууллагын нэр хүнд алба хаагч нэг бүрийн нэр төрөөс шууд шалтгаална гэдгийг байнга анхаарч байх;

2.4.6.алба хаагч нь хууль тогтоомжоор ногдуулсан албан үүргээ зохих ёсоор хэрэгжүүлэх, хэрэг маргааны асуудлыг чирэгдэлгүй, сунжуулахгүй шийдвэрлэхэд нэн шаардлагатай мэдлэг, мэргэжлийн ур чадварыг эзэмших талаар байнгын хичээл зүтгэл гарган, чармайлттай ажиллах бөгөөд дээд шатны удирдах албан тушаалтан дэмжлэг үзүүлэх;

2.4.7.мөрийтэй, бооцоотой тоглоом, иргэний хувьд хуулиар хориглосон тоглоом тоглох, зохион байгуулахад оролцохгүй байх;

2.4.8.ажлын байранд, ажлын цагаар эсхүл албан үүрэг гүйцэтгэж явахдаа болон цагдаагийн дүрэмт хувцастай согтууруулах ундаа хэрэглэх, хуулиар хориглосон газарт утаат тамхи татахгүй байх;

2.4.9.мансууруулах болон сэтгэцэд нөлөөлөх бусад эм, бэлдмэл болон бусад бодис хэрэглэхгүй байх;

2.4.10.олон нийтийн газар, авто зам, гудамж талбайд бие засах, эсхүл нус

цэр, шүлс, тамхины иш, хог хаяхгүй байх;

2.4.11. согтууруулах ундааны зүйл хэрэглэсэн үедээ тээврийн хэрэгсэл жолоодохгүй байх;

2.4.12. шалгаж байгаа өргөдөл, гомдол, хэрэг, маргааны оролцогчидтой хувийн харьцаа тогтоохгүй байх;

2.4.13. гэр бүл, үр хүүхдэдээ хайр, халамжтай байж, нийтээр зөвшөөрөгдсөн хэм хэмжээг сахиж мөрдөх;

2.4.14. олон нийтийн цахим сүлжээ, мэдээллийн сувгуудад зөвшөөрөгдсөнөөс бусад тохиолдолд албаны мэдээ, мэдээлэл оруулахгүй, ажлын цагаар хувийн асуудлаар цахим сүлжээнд орохгүй байх;

2.4.15. цагдаагийн дүрэмт хувцас, албаны үнэмлэх, тэмдэг, тусгай болон техник хэрэгслийг бусдад дамжуулах, хэрэглүүлэх, бусдад барьцаа болгон үлдээхгүй, хаяж үрэгдүүлэхгүй байх;

#### **Гурав. Хариуцлага**

3.1. Цагдаагийн алба хаагчийг ёс зүйн хэм хэмжээг зөрчсөн үйлдэл, эс үйлдэхүйг албан тушаал, цол, ажилласан жилийг үл харгалзан шалгаж шийдвэрлэнэ.

3.2. Ёс зүйн зөрчил гаргасан цагдаагийн алба хаагчид эрх бүхий албан тушаалтан Цагдаагийн албаны тухай хуулийн 81 дүгээр зүйлд заасан сахилгын шийтгэлийн аль нэгийг тухайн зөрчлийн шинж байдал, түүнийг анх буюу давтан үйлдсэнийг харгалзан, дэс дараалан хэрэглэхгүйгээр оногдуулна.

3.3. Сахилгын шийтгэл хүлээсэн алба хаагч Цагдаагийн албаны тухай хуулийн 81 дүгээр зүйлийн 81.6 дахь хэсэгт заасны дагуу ёс зүйн сургалтад хамрагдах үүрэгтэй.

3.4. Ёс зүйн хэм хэмжээг ноцтой зөрчсөн алба хаагчийг Цагдаагийн албаны тухай хуулийн 82 дугаар зүйлийн 82.1.1-д заасны дагуу албанаас хална.

3.5. Ёс зүйн зөрчил гаргаж сахилгын шийтгэл хүлээсэн алба хаагчийг Цагдаагийн албаны тухай хуулийн 81 дүгээр зүйлийн 81.9 дэх хэсэгт заасныг баримтлан, хугацаанаас өмнө сахилгын шийтгэлгүйд тооцож болно.

3.6. Ёс зүй зөрчсөн алба хаагчид сахилгын шийтгэл ногдуулахтай холбогдсон харилцааг Цагдаагийн байгууллагын үйл ажиллагааны журмаар зохицуулна.

#### **Дөрөв. Бусад**

4.1. Ёс зүйн дүрмийн хэрэгжилтэд цагдаагийн төв, алба, нэгж, нутаг дэвсгэр хариуцсан цагдаагийн байгууллагын дарга нар өдөр тутам хяналт тавьж ажиллах ба цагдаагийн алба хаагч энэхүү дүрмээр хүлээсэн хэм хэмжээг сахин мөрдөх нөхцөлийг бүрдүүлэх үүрэгтэй.

4.2. Ёс зүйн хэм хэмжээг хэрхэн сахин биелүүлж байгаа нь алба хаагчийг шагнаж, урамшуулах, өөр албан тушаалд дэвшүүлэх, шилжүүлэх, сэлгэн ажиллуулах, албан тушаал бууруулах үндэслэл болох бөгөөд ёс зүйн хувьд бусдад үлгэр дуурайлал үзүүлсэн, иргэд, байгууллагын талархал хүлээсэн алба хаагчийг дараах байдлаар урамшуулж болно:

4.3.1. хамт олны өмнө сайshaаж хувийн хэрэгт тэмдэглэх;

4.3.2. цалинг үр дүнгээр нэмэх /тэтгэмж, мөнгөн урамшуулал олгох/;

4.3.3. боловсрол мэдлэгээ дээшлүүлэх, сургалтад хамрагдах эрх олгох;

4.3.4. цалинтай амралт, сувиланд хамруулах;

4.3.5. цагдаагийн байгууллагын болон салбарын шагналд шагнуулахаар тодорхойлох;

4.3.6. албан тушаал дэвшүүлэх саналыг эрх бүхий албан тушаалтанд уламжлах.

Цагдаагийн ерөнхий газрын даргын  
2022 оны 6 дугаар сарын 28-ны  
өдрийн 7 дугаар тушаалын  
хоёрдугаар хавсралт

## ЦАГДААГИЙН АЛБА ХААГЧИЙН САХИЛГЫН ДҮРЭМ

Нэгдүгээр зүйл. Ерөнхий зүйл

1.1. Цагдаагийн алба хаагчийн сахилгын дүрмийн зорилго нь цагдаагийн албаны хэвийн үйл ажиллагаа, захирах захирагдах ёс, хүний эрхийг хангах, алба хаагчийн сахилгын хэм хэмжээг тогтоох, хариуцлагыг журамлан зохицуулах замаар тэдний эрх, хууль ёсны ашиг сонирхол, цагдаагийн байгууллага, алба хаагчийн нэр хүндийг хамгаалахад оршино.

1.2. Цагдаагийн алба хаагч нь Монгол Улсын хууль тогтоомж, тэдгээрт нийцүүлэн гаргасан эрх зүйн акт болон байгууллагын дотоод журам, цагдаагийн алба хаагчийн тангаргаар хүлээсэн үүргээ чанд сахин биелүүлэхийг цагдаагийн алба хаагчийн сахилга гэнэ.

1.3. Цагдаагийн алба хаагчийн сахилгын дүрэм /цаашид “Сахилгын дүрэм” гэнэ/ нь цагдаагийн алба хаагчдад тавигдах нийтлэг шаардлага, зарчим, сахилгын зөрчлийн төрөл, хэлбэрийг тодорхойлно.

1.4. Алба хаагч нь Монгол Улсын хууль тогтоомж, тэдгээрт нийцүүлэн гаргасан эрх зүйн акт болон байгууллагын дотоод журам, цагдаагийн алба хаагчийн тангаргаатaa үнэнч байж, үүрэг болон хууль тогтоомжийг чанд сахин биелүүлнэ.

1.5. Энэ дүрэмд хэрэглэсэн дараах нэр томьёог дор дурдсан утгаар ойлгоно:

1.5.1. “**цагдаагийн алба хаагчийн сахилга**” гэж Монгол Улсын хууль тогтоомж, тэдгээрт нийцүүлэн гаргасан эрх зүйн акт болон байгууллагын дотоод журам, цагдаагийн алба хаагчийн тангаргаар хүлээсэн үүргээ чанд сахин биелүүлэхийг;

1.5.2. “**сахилгын зөрчил**” гэж холбогдох хууль тогтоомж болон энэ дүрмээр тогтоосон сахилгын хэм хэмжээг зөрчсөн үйлдэл, эс үйлдэхүйг;

1.6. Цагдаагийн алба хаагчийн сахилга нь энэ дүрмээр тогтоосон хэм хэмжээг сахиж биелүүлснээр тодорхойлогдоно.

1.7. Цагдаагийн алба хаагч бүр өргөсөн тангаргаатaa үнэнч байж, түүнийг ёсчлон биелүүлж, сахилгын дүрмийг сахин биелүүлэх үүрэгтэй.

1.8. Цагдаагийн байгууллагын удирдах албан тушаалтан сахилга, дэг журмыг бэхжүүлэх талаар үр дүнтэй арга хэмжээ аваагүй, алба хаагчдад буруу үлгэр дуурайлал үзүүлж, албан тушаалын бүрэн эрхээ урвуулан ашиглах, хувийн ашиг сонирхолдоо нийцүүлэн бусдыг аливаа хэлбэрээр хавчин гадуурхах, эрхшээлдээ байлгах, түүнчлэн дарамт, хүчирхийлэл, бэлгийн дарамт үзүүлэх, хууль бус тушаал, шийдвэр биелүүлэхийг шаардах нь сахилгын шийтгэл хүлээлгэх үндэслэл болно.

1.9. Алба хаагч нь үйл ажиллагаанд Төрийн албаны тухай хуулийн 7 дугаар зүйл, Цагдаагийн албаны тухай хуулийн 5 дугаар зүйлд заасан зарчмыг тус тус баримтална.

Хоёрдугаар зүйл. Сахин баримтлах хэм хэмжээ

2.1. Монгол Улсын Үндсэн хууль, Монгол Улсын нэгдэн орсон олон улсын гэрээний Цагдаагийн үйл ажиллагаанд холбогдох заалт, НҮБ-ын Ерөнхий Ассамблейн 1979 онд баталсан Хууль хэрэгжүүлэх албан тушаалтнуудын зан үйлийн тухай хууль, Интерполоос баталсан дүрэм, журам, Монгол Улсын хууль тогтоомж, Цагдаагийн тангараг, Цагдаагийн алба хаагчийн ёс зүйн дүрэм, Цагдаагийн төв байгууллагаас тогтоосон цагдаагийн

байгууллагын хөдөлмөрийн дотоод буюу үйл ажиллагааны журам болон энэ дүрмийг алба хаагч бүр дагаж мөрднө.

2.1.1.Алба хаагчийн үйл ажиллагаанд хяналт тавьж удирдлагаар хангах эрх бүхий албан тушаалтны хуульд нийцсэн зөвлөмж, шийдвэрийг дагаж мөрдөх;

2.1.2.Албаны болон алба хаагчийн нэр хүндийг хамгаалж, хүний эрх, эрх чөлөөг хүндэтгэж, хууль тогтоомжид заасан үндэслэл, журмын дагуу үйл ажиллагаа явуулах;

2.1.3.Улс төрөөс ангид байж, санаа бодлоо илэрхийлэх, эвлэлдэн нэгдэх, уг хэлэх, хэвлэн нийтлэх, шашин шүтэх, эс шүтэх эрхээ эдлэхдээ албандаа хүндэтгэлтэй хандаж, алба хаагчийн ёс зүйд харш үйлдэл, эс үйлдлийг гаргахгүй байх;

2.1.4.Албан үүргээ биелүүлэхдээ байгууллагын үнэт зүйл, эрх ашгийг ямагт эрхэмлэн дээдэлж, амин хувийн эрх ашигт автахгүй, авлига, ашиг сонирхлын зөрчлөөс ангид байх;

2.1.5.Албан тушаалын байдлаа урвуулан ашиглах, танил тал харах, аливаа этгээдийн өмнө хууль бус үүрэг хүлээх, албан үүргээ хэрэгжүүлсний төлөө бэлэг, дурсгал, шан харамж авахгүй байх;

2.1.6.Үндсэн ажил, албан үүргээсээ гадуур хуулиар хүлээн зөвшөөрснөөс бусад ажил, албан тушаал хавсан гүйцэтгэхгүй байх;

2.1.7.Албан үүрэгтэй холбоотой нь илэрхий болсон буюу эсвэл өөрт нь итгэмжлэн мэдэгдсэн төрийн болон албаны, хувь хүний нууцыг задруулахгүй байх;

2.1.8.Удирдлагын зөвшөөрөлгүйгээр албан ажлын талаар нийтэд болон бусдад мэдээлэл өгөх, мэдээлэл дамжуулахгүй байх;

2.1.9.Чиг үүргийн дагуу аливаа асуудлыг шалгахдаа танил тал харах, бусдыг ялгаварлах, хүнд суртал гаргах, чирэгдүүлэх, хийх ёстай үйлдлээ хийхгүй байх зэргээр хүний эрх, эрх чөлөөг үл хүндэтгэх байдал гаргахгүй байх;

2.1.10.Байгууллагын өмч хөрөнгө, техник болон тусгай хэрэгсэл, албан хэрэгцээний мэдээ материал, мэдээллийн санг албаны бус зориулалтаар ашиглахгүй байх;

2.1.11.Байгууллагын даргын зөвшөөрөлгүйгээр албаны болон хувийн ажлаар гадаад улсад зорчих, түүнчлэн дотоод, гадаадын байгууллага, аж ахуйн нэгж, хувь хүний зардлаар аялах, жуулчлах, амрахгүй байх;

2.1.12.Аливаа уулзалт, дайллага, хүлээн авалтад оролцохдоо албаны нэр хүндийг дээдэлж, хөндлөнгийн ямар нэг нөлөөнд автахгүй байх;

2.1.13.Албан үүргээ гүйцэтгэхэд иргэн, албан тушаалтнаас нөлөөлсэн дарамт шахалт, зохимжгүй нөлөөллийн талаар дээд шатны удирдлагад мэдэгдэх;

2.1.14.Албаны үнэмлэх, тэмдгийг хууль бусаар хэрэглэх, албаны нэрийг хувийн ашиг сонирхлоор ашиглахгүй байх.

### Гуравдугаар зүйл.Сахилгын шийтгэл ногдуулах үндэслэл

#### 3.1.Цагдаагийн албан хаагчид дараах үндэслэлээр сахилгын шийтгэл ногдуулна.

3.1.1.Цагдаагийн албаны тухай хууль болон холбогдох бусад хууль тогтоомж, ёс зүйн дүрмийг зөрчсөн;

3.1.2.Удирдах албан тушаалтнаас хуулийг дагаж мөрдөх талаар гаргасан хуульд нийцсэн тушаал, үүрэг даалгаврыг хэрэгжүүлээгүй;

3.1.3.Байгууллагын дотоод дүрэм, журам зөрчсөн;

3.1.4.Хуульд заасан албаны чиг үүрэг, албан тушаалын тодорхойлолтод заасан зорилго, зорилтоо хүндэтгэн үзэх шалтгаангүйгээр биелүүлээгүй;

3.1.5.Цагдаагийн албан хаагчийн ажлын хариуцлага, мэргэжлийн ур чадвараас шалтгаалсан алдаанаас хууль тогтоомж зөрчигдсөн нь тогтоогдсон.

3.2. Сахилгын шийтгэл ногдуулах үндэслэл, зөрчлийг холбогдох хууль тогтоомжийн хүрээнд заавал шалгаж тогтоосон байна.

Дөрөвдүгээр зүйл. Сахилгын дүрэм зөрчсөн албан хаагчид хүлээлгэх хариуцлага

4.1. Энэ дүрэмд заасан сахилгын хэм хэмжээг зөрчсөн нь тухайн алба хаагчид Цагдаагийн албаны тухай хууль болон холбогдох бусад хуульд заасан хариуцлага ногдуулах үндэслэл болно.

4.2. Алба хаагчид сахилгын шийтгэл хүлээлгэхтэй холбогдсон харилцааг Цагдаагийн байгууллагын үйл ажиллагааны журмаар зохицуулна.

---oOo---